

**Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 5 дугаар сарын байдлаар)**

**I. Нийгмийн үзүүлэлт**




**I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.**

2016 оны 5 дугаар сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1005 болж, 2015 мөн үеэс 145 хүнээр өсч, өмнөх сарынхаас 58 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 48.26 хувь буюу 485 нь эмэгтэйчүүд юм. 2016 оны эхнээс 411 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 293 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 36.52 хувь буюу 107 нь эмэгтэйчүүд байв.

Зураг I.1

**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 5 дугаар сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр**




Тайлант сард бүртгүүлсэн 345 ажилгүй иргэний 22.32 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 19.13 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 12.46 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 11.01 хувь нь орон тооны цомхтголд орсон; 8.70 хувь нь шилжин суурьшсан; 4.35 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 3.19 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 2.90 хувь нь цэргээс халагдсан; 2.32 хувь нь байгууллага татан буугдсан; 1.74 хувь нь

одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 0.58 хувь нь хорих газраас суллагдсан; 0.29 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 11.01 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 5 дугаар сарын эцэст**



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



**I.2 Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 5 сард НДШ-ийн орлого 6.42 тэрбум ₮ болж төлөвлөгөө 98.65 хувь болж, төлөвлөгөөг Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянцогт, Жаргалант, Лүн, Өндөрширээт, Угтаал, Цээл, Эрдэнэсант сумд 2.07-26.87 хувиар давуулан биелүүлж. 18 сум 0.82-15.98 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 517.1 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 15.8 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр,

тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 260840 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 37.94 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 23.07%; тэтгэмжийн даатгалын сангийн 80.10%; эрүүл мэндийн даатгалын сангийн 153.88%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 139.91%; ажилгүйдлийн даатгалын сангийн 106.94%-ийг тус бүр бүрдүүлжээ.

#### **Нийгмийн халамж**

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 5 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 49180 хүнд олгож, 5.2 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 47.9 хувь 45327 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 8.4 хувь 411.8 сая ₮-өөр өслөө.

#### **Мөнгө, зээл, хадгаламж**

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 5 сард кассын орлого 174.1 тэрбум ₮, кассын зарлага 176.5 тэрбум ₮ болж, гүйлгээнд 171.1 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 85131, зээлийн багцын дүн 277.4 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 28524, олгосон зээлийн дүн 57.3 тэрбум ₮ боллоо.

Иргэдийн хувийн хадгаламжинд 5 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 33.5 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 8.4 тэрбум ₮ байна.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 0.76-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



## **II.2 Төсөв, мөнгө**

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 14.3 хувь буюу 362.3 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 89.2 хувийг татварын, 9.8 хувийг татварын бус, 1.0 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 10.1 нэгжээр өсч, татварын бус орлого 10.7 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.6 нэгжээр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 3677.8 сая ₮ болж аймгийнх 2545.7 сая ₮ буюу 69.2 хувь, сумынх 354.5 сая ₮ буюу 9.6 хувь, улсынх 777.6 сая ₮ буюу 21.1 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 19.7 хувь буюу 191.8 сая ₮-өөр өсч 1.1 тэрбум ₮ болж, авлага 1.5 дахин буюу 248.8 сая ₮-өөр өсч 406.2 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 2.9 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 92.8 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 354.5 сая ₮ болж, төлөвлөгөө 84.1 хувь биелж, Угтаал, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Баянхангай, Баян, Сэргэлэн, Заамар, Баянцагаан, Аргалант, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэсант, Борнуур, Зуунмод, Бүрэн, Архуст, Жаргалант, Эрдэнэ, Сүмбэр сумд 77.1-5.0 хувиар тасалдууллаа. Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 2.5 тэрбум ₮ болж 98.1 хувь биелж Баянцагаан, Жаргалант, Эрдэнэ, Өндөрширээт, Баян, Баянцогт, Угтаал, Алтанбулаг, Баянхангай, Баяндэлгэр, Архуст, Зуунмод, Эрдэнэсант, Сүмбэр, Баянчандмань, Баянжаргалан, Борнуур, Дэлгэрхаан, Мөнгөнморьт сумд төлөвлөгөө 44.4-0.2 хувиар тасалдууллаа.



## **II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ**

2016 оны 5 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12

дугаар сараас 66.80%, өмнөх оны мөн үеэс 5.63%, өмнөх сараас 0.19 хувиар тус тус өсөв.

### Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ХҮИ өмнөх оны мөн үеэс 5.63% өссөний дотор боловсролын үйлчилгээний бүлэг 32.5%; хувцас бөс бараа гутлын бүлэг 8.88%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 5.96%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.83%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 5.39%; тээврийн бүлэг 5.10%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 4.03%; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 1.87%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 1.68%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.10%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 4.18%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.24%-аар тус тус буурч үнэ тогтвортой байв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 оны 5 сард	2015 оны 5 сард
	пунктээр	хувиар
<b>Бүгд</b>	<b>0.19</b>	<b>100.00%</b>
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.08	29.75%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.09	47.19%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.00	0.00%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮҮШ	0.00	0.00%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.00	0.00%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.02	-11.31%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.06	31.94%



## II. Төл бойжилт

6 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 73.4 хувь

1458.4 мянган хээлтэгч мал төллөж, 1466.4 мянган төл гарсны 97.4 хувь 1428.1 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 5.4 хувь буюу 84.2 мянгаар; бойжиж буй төл 5.2 хувь 78.2 мянгаар буурч; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 33.3 хувь 363.9 мянгаар, бойжиж буй төл 35.5 хувь 374.3 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 41.5; гүүний 44.0; үнээний 53.3; эм хонины 78.8; эм ямааны 73.5 хувь нь тус бүр төллөв. Гарсан төлийн 2.6 хувь 38284 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 13.0 хувь буюу 5742 төлөөр; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 18.3 хувь буюу 8556 төлөөр буурлаа. Гарсан ботгоны 2.3, унаганы 2.7, тугалын 2.6, хурганы 2.0, ишигний 3.6 хувь нь тус бүр хорогдов. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянчандмань, Өндөрширээт, Сэргэлэн, Баян-Өнжүүл, Баянцогт сумд гарсан төлийнхөө 12.4-7.8 хувь буюу 5942-1573 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 45.7 хувийг (бүгд 17530 төл) эзлэв.

## Том малын зүй бус хорогдол

6 сарын 1-ний байдлаар оны эхний малын 1.8 хувь буюу 81676 том мал зүй бусаар хорогдсон нь 2015 оны мөн үеэс 1.4 дахин буюу 48285 толгойгоор; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 2.4 хувь буюу 1972 толгойгоор тус бүр өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянцогт, Баянчандмань, Угтаал, Баянхангай, Бүрэн сумд оны эхний малынхаа 11.76-2.97 хувь буюу 12705-9510 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 44.0 хувь (бүгд 35975) эзлэв.

Оны эхний тэмээний 0.5, адууны 1.5; үхрийн 2.9; хонины 1.4; ямааны 2.3 хувь нь

тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 2.9 хувь нь өвчнөөр, 31.9 хувь нь хээлтэгч мал эзлэв.




## II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2016 оны эхний 5 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 4.02 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 1.0 дахин буюу 4.0 тэрбум ₮-өөр буурлаа.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, оны үнээр, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2014 V	2015 V	2016 V	2016 V / 2015 V %
Нийт дүн	9.98	9.79	12.84	131.2%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	3.67	3.36	6.77	201.5%
Боловсруулах аж үйлдвэр	2.24	3.3	2.39	72.4%
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	3.38	3.13	3.68	117.6%


Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл, хэвлэн нийтлэх, цахилгаан дулааны үйлдвэрлэл өмнөх оноос 95.6-6.4 хувь буюу 381.0-1.3 сая ₮-өөр буурсан нь нөлөөлөв.



Оны эхний 5 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 20.72, боловсруулах үйлдвэрлэл 17.81,

ашигт малтмал олборлолт 61.47 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, хувиар




## II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2016 оны эхний 5 сард 570.0 сая ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулахад 0.8 дахин буюу 479.0 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 57.27 хувь нь инженерийн барилга байгууламжид; 26.24 хувь нь орон сууцны бус барилгад; 16.49 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2015 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 13.95 пунктээр, орон сууцны барилгын ажил 16.49 пунктээр тус тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 30.44 пунктээр буурав.

Зураг II.8

Барилга угсралт, их засварын ажил жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, сая.₮








## II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 5 сард 73.4 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 36.1 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.32 хувь буюу 9.4 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 43.2 сая ₮ болсон ба нийт орлогын 79.8 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 20.19 хувийг албан бичгийн, 11.86 хувийг зорчигчдын, 67.95 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Зураг II.10

### Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



### Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 5 сард нийт 1648 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 47; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 436; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 4; бэлэглэлийн гэрээ 17; худалдах, худалдан авах гэрээ 83; өв залгамжлал 6; барьцааны гэрээний бүртгэл 735; бусад бүртгэл 320 тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 5 сард нийт 63 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 36 ; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 13; шашин 3; боловсрол сургалтын байгууллага /БСБ/ 1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 4; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 4; Төсөвт 2; Хоршоо 1 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 5 сарын мэдээгээр 119 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 24; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 19; дүрэм шинэчилсэн 3; дахин гэрчилгээ 8; удирдлага өөрчлөгдсөн 18; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 10; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 16; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр өөрчлөгдсөн 9; татан буугдсан 10; тус бүр бүртгүүллээ. Мөн 35 иргэн, 11 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

### Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 5 сарын мэдээгээр нийт 80 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 247; үүнээс тохирлын гэрчилгээ 207, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 40; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 1621; үүнээс цулын хэмжүүр 295, жин 242, туухай 49, автомашины жин 4; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 198; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 127, мерник 6, сүмбэн метр 13, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 9, уртын хэмжих хэрэгсэл 7, усны тоолуур 36; нэг фазын тоолуур 1106, гурван фазын тоолуур 22; даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.